## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 15 Улаанбаатар хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ ӨГӨХ БОЛЗОЛ,

### ЖУРАМ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгийн хуудасны загвар"-ыг 2 дугаар хавсралтаар, "Төрийн албаны нөөцөд бүртгэх хүснэгтийн загвар"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсяугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

3.Энэ журам батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 05, 12, 16, 20, 50 дугаар, 2013 оны 86 дугаар, 2014 оны 08, 12, 33, 43, 72, 73 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТ ӨГӨХ БОЛЗОЛ,

### ЖУРАМ, ЗАГВАР БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн албаны тусгай шалгалтын нэгдсэн үнэлгээний хуудас"-ны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус батлаcугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

3.Энэ журам батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн "Заавар батлах тухай" 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

**2019 оны 5 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 25** **Улаанбаатар хот**

**Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг**

**сонгон шалгаруулах журам батлах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээний хуудас"-ны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

3.Энэ журам батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн "Журам батлах тухай" 60 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.